

## **Ажлын нэгэн үеийн дурсамж**

Миний бие Төв аймгийн Заамар сумын Засаг даргын орлогч ажилтай, Би 1962 онд Говь-Алтай аймгийн Баян – Уул суманд малчин ардын гэр бүлд төрсөн. Сумын 10 жилийн сургууль, Завхан аймгийн худалдааны сургууль төгсөөд 1983 онд Заамар суманд ирж нэгдлийн бичээч, данс хөтлөгч, нярав, тооцооны ня-бо, 1991 оноос Эрчим хүчний салбар, ЗДТГ-т нягтлан бодогчийн ажлуудыг хийж байгаад 2002 онд сумын Засаг даргын орлогчийн албан тушаалд томилогдсон. Өмнө нь бүртгэл тооцооны л ажил хийж байсан болохоор даргын ажил хийхэд багагүй бэрхшээл тулгарч байсан хэдий ч сумын Засаг даргаар М.Эрдэнэдалай дарга ажиллаж байсан, миний мэдэхгүй чадахгүй ялангуяа бичиг тоот төлөвлөөд ороход улаан балаар засаж, утга найрлага, хууль эрх зүйн дүрмийн талаар зөвөлгөө өгч, улаан эрээнээр цоохорлоод өгдөг байсан нь миний хойшдын ажилд ихээхэн мэдлэг чадварыг өгч байсныг дурьдах нь зүйтэй юм.

Тэр үед Засаг даргын орлогчийн ажлын гол нь сумын нийгэм, эдийн засгийн бүхий л тоон үзүүлэлтийн судалгааг бүрдүүлэн дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч, цаашид дэвшүүлэх зорилт, авах арга хэмжээг тодорхойлдог, статистикийн мэдээг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудаас цуглуулан авч нэгтгэн холбогдох газарт нь явуулдаг байлаа. Улсын Их Хурлаар Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжүүлтийн хууль батлагдан хэрэгжсэн 2003.01.01-нээс эхлэн төрийн сангийн тогтолцоонд орсноор төрийн сангийн төлөөлөгчийн ажлыг давхар хийж байлаа. Энэ үед ажлын ачаалал нилээд нэмэгдсэн тул өөртөө ажлын хуваарь гарган, өдрийн цагт төрийн сангийн төлбөр тооцооны ажлаа хийж, оройн 18-22.23 цаг хүртэл статистикийн мэдээ, тооцооныхоо ажлыг амжуулдаг байлаа. Энэ нь оройн цагаар хүний хөл хөдөлгөөн багасч, тооцоо судалгааны ажил хийхэд анхаарал төвлөрч бодож тооцоолоход илүү үр дүнтэй байсан бөлгөө. Сумын хэмжээний бүхий л салбарын статистик мэдээллийг нэгтгэн авч, мэдээллийн сан бүрдүүлэн 5-10 жилийн судалгаатай ажиллаж байсан. Ер нь статистикийн албаны үйл ажиллагааны хамгийн гол тулгуур нь анхан шатны үнэн бодитой мэдээлэл

байдаг. Энэ мэдээ судалгааны ажлын хувьд чадахгүй мэдэхгүй зүйл их гарч байсан. Энэ хугацаанд аймгийн статистикийн хэлтсийн даргаар Отгончулуун, мэргэжилтнээр Дууяа эгч, Аюуш гуай, Баатар, Ундрахбаяр, Энхбаатар, Одгэрэл, Бямбасүрэн нар ажилладаг байсан ба эдгээр туршлагатай хүмүүсээс ихийг сурсан даа. Ялангуяа Отгоо дарга, Дууяа эгч, Аюуш гуай 3-аас байнга утсаар асууна, зөвөлгөө авна, судалгааны ажилд нь хамт явах зэргээр эдгээр хүмүүсийнхээ ач тусаар статистикийн ажлыг хийх сонирхол улам их нэмэгдсэн юм. Ийм дадлага туршлагатай, эвсэг, нөхөрсөг хамт олонтой ажиллаж их юм сурч мэдэж авсан нь надад хэзээ ч мартагдахааргүй сэтгэгдэл үлдээсэн юм даа. Статистик гэдэг бол жирийн хүний нүдээр харахад жирийсэн олон тоо байдаг боловч угтаа тэр нь эх орны амьдрал үйлсийг тоон хэлээр түүх болгон үлдээж байгаа хамгийн чухал бичиг баримт гэж боддог. Би ийнхүү ажиллах хугацаандаа Үндэсний статистикийн салбарын хэмжээнд “2007 оны статистикийн шилдэг ажилтан”, “Бүртгэл статистикийн тэргүүний ажилтан”, 2010 оны аймгийн шилдэг статистикийн ажилтан” зэрэг шагналуудыг хүртсэн нь статистикийн хэлтсийн хамт олны минь ажлын амжилт үр дүнтэй салшгүй холбоотой гэж бодож энэ хэлтсийн хамт олноороо бахархаж явдаг юм. Мөн суманд ҮСГ-аас DELL маркийн компьютерээр шагнуулж байсныг өдүгээ хүртэл өөрийн албан хэрэгцээндээ ашиглаж байна.

Ингэж ажиллаж байх хугацааны ажил, амьдарлыг бага ч болов сэргээн сануулах хоёр бяцхан дурсамжаа дурдъя:

1.Би 2004 оны шинэ жилээр аймгийн статистикийн хэлтсийн хамт олондоо шинэ жилийн мэнд хүргэж дараах өөрийн бодож санасан зүйлээ бичиж явуулсан юм.

Шинэ оны мэнд хүргэе. С новым годом. Happy New year.

Хадаастай сандал дээр суусан юм шиг

Босч гүйсэн хэцүү хүн

Хаана ажил яаж байна гээд

Зовж гүйсэн хачин хүн  
Эрх нь гацахгүй бол  
Эрхий нь гацахгүй үеийн хүн  
Энэ үеийн цахим тооцоолуураас  
Элбэгдэж төрсөн буурал нягтлан

Дуугарч ярих нь намуухан ч гэлээ

Дүгнэж нягтлах нь чанга даа

Байгаа дүр нь намбалаг ч гэлээ

Байцааж тушаахдаа хатуухандаа

Урлаг гэвэл гараад өгнөө

Сурлага гэвэл гавал толгой

Урдах ажлаа гялалзуулж өгнөө

Угтаа би чинь санхүүч хүн шүү /Хэн хэн бэ таагаарай гээд явууллаа/ Тэр үед Отгончулуун дарга, мэргэжилтэн Дуламсүрэн эгч, Аюуш гуай, Баатар нар ажиллаж байсан. Он гараад ажиллах хүчний судалгаа тушаахаар очиход Отгоо дарга маань “Баярцэцэг хүн доромжилсон чамайг цагдаад өгнө” гээд инээмсэглэж байлаа. Би ч тоглоомоор хэлж байна гэж бодсон ч “за би хэлтсийн хамт олныхоо шинэ оны мэндийг мэдэж, өөрийн сэтгэлд бодож явсан магтаалын үгээ хэллээ гэж бодсон юмсан гэтэл даргад маань таагүй сэтгэгдэл төрүүлжээ бусдад нь ямар санагдсан болдоо” гэж бодоод сэтгэл өвдөж байлаа. Яагаад би Отгончулуун даргаа тэгэж шүлэглэсэн гэвэл Отгоо дарга маань байнга ажлын төлөө л төрсөн хүн шиг санагддаг. Ээлжийн амралт эдэлдэггүй, өглөө эрт, орой шөнө дөл болсон ч өрөө нь гэрэлтэй ажил дээрээ сууж л байдаг, өрөөнд нь ороход ажил л ярьж байдаг, ар гэр ахуй амьдралаа умартан ажлаа хийж байдаг хүн дээ.

Статистикийн хэлтсийн мэргэжилтнүүдийн өрөө бол сумдын орлогч нарын нэг гэр нь юм шиг л бид нар тэнд цугларна, халуун цай кофе, печенээр дайлуулна, орой болоод хонох газар /буудал/ олдохгүй бол ажлаа хийгээд хононо, одоо ч гэсэн энэ хэлтсээр орох ажилгүй мөртлөө заавал орж гарч явдаг реплекс тогтсон нь энэ хэлтсийн хамт олон бид бүхнийг хүнлэг чанар, хөдөлмөрч, эелдэг зөөлөн уур амьсгалаар угтаж хүлээн авдагтай холбоотой

билээ. Хэлтэс маань жил бүр бидний ажлыг тодорхой үзүүлэлтүүдээр дүгнэж, тэргүүний байруудыг шагнана. Би ч эхний 5 байраас буудаггүй байнга л шагнуулдаг байлаа. Ийм болохоор хийж байгаа ажилдаа улам урамшиж, чадахгүй ч гэсэн цаашдаа яаж ажиллах вэ?, ямар шинэ санаа олох вэ? гэж толгойгоо гашилгаж явдаг үе байсан шүү

2. Үндэсний Статистикийн Газар, аймгийн статистикийн хэлтсийнхэнтэй хамтран 2003 оны 9-р сард сумдын Засаг даргын орлогч нарыг “Найрамдал” зусланд 3 хоногийн сургалтанд хамрууллаа. Сургалт өглөөний 9 цагаас 13 цаг, 14 цагаас 18 цагийн хооронд болно. Сургалтаасаа тараад хоолондоо орчихоод 1 өрөөндөө цугларч шөнөжингээ дуулж бүжиглэж, шуугилданаа. Хэлтсийн дарга маань одоо унтацгаа өглөө дахиад сургалттай гээд ороод ирнэ. Даргыг байхад “за унтлаа” гээд өрөө өрөөлүүгээ явж орондоо орно доо. Жаахан байж байгаад даргыг унтсан байх гэхийн алдад дахиад л босож коридороор гутлаа бариад оймстойгоо явж /чимээ гаргахгүйн тулд/ нөгөө өрөөндөө цугларч бие биенээ явуулж, онигоо ярьж хөгжилтэйгээр сургалтанд оролцож билээ. Мөн сургалт, семинарт хожигдсон минутаар торгууль хүлээнэ. Нэг минут 100 төгрөг 30 минут хожигдоход 3000 төгрөг төлнө. Тэр үед орлогч нарын ангийн дарга Цэндсүрэн гуай /Зуун мод сумын орлогч/ байсан юм. Нарийн бичиг нь олон хүн байлаа. Архустын Насанжаргал, Атарын Нараа эгч. Баяндэлгэрийн Насаа гээд, нарийн бичгүүд нь цаг бүртгэж торгуулийн мөнгөө хураадаг учир хэн хэн ямар хугацаагаар хожигдож ирэх бол гээд бүртгэлийг яс бүртгэнэ дээ. Хураасан торгуулийн мөнгөө семинар тараад хамт хоолонд орох, өвчтэй, гачигдалтай зарим нэгэндээ тусламж өгөх зэрэгт зарцуулдаг байв. Бас шинээр ажилд орсон хүмүүсийг ангидаа элсүүлэн авахад тусгай журамтай, хамт олноороо хэлэлцэж элсүүлнэ. Шинээр ажилд орсон зарим нэг нь түүнийг мэдэхгүй 2-3 удаа элсэж байсан түүхтэй. Учир нь манай архагууд Мөнхбаатар, Буяндалай гэх мэт хүмүүс урьдчилаад элсүүлчихдэг байжээ...

За ингээд нэгэн үеийн дурсамжийн түүхээ хамт ажиллаж байсан нөхөддөө

толилуулав.

Төв аймгийн Заамар сумын Засаг даргын орлогч

Чулуунхүү овогтой Баярцэцэг

2014.11.06